

НУТАГ ДЭВСГЭР ХАРИУЦСАН ЦАГДААГИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН ДАРГА НАРТ

*“Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын
эсрэг гэмт хэргийн нөхцөл байдлын танилцуулга”*

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11 дүгээр бүлэг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 2015-2017 оны статистик тоо мэдээ, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн дүнг танилцуулж байна.

Нэг. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг


Улсын хэмжээнд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2015-2017 онд 25124 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 29 хувийг бөгөөд 15134 нийслэлд, 9969 орон нутагт, 21 бусад газар үйлдэгдсэн байна.

Энэ төрлийн гэмт хэргийг сүүлийн 3 жилийн дунджаар авч үзвэл жилд 8374, сард 697, өдөрт 23, цаг тутамд 1 гэмт хэрэг бүртгэгджээ.

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2017 онд 8812 бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх онтой харьцуулахад 564 буюу 6.8 хувиар өссөн бөгөөд 5392 буюу 61.1 хувь нь нийслэлд, 3420 буюу 38.8 хувь нь орон нутагт үйлдэгджээ. Хэргийн илрүүлэлт 58.8 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 29.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Дээрх гэмт хэргийн 89.6 хувь нь хөнгөн, 5.7 хувь нь хүндэвтэр, 4.5 хувь нь хүнд ангиллынх байна.

Зураг 1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо, үйлдэгдсэн нутаг дэвсгэрээр, /2015-2017он/




Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3 хэрэг тутмын нэг нь согтуугаар, 4 хэрэг тутмын нэг нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүн, 5 хэрэг тутмын нэг нь бүлэглэн үйлдэгдсэн тоон үзүүлэлт гарч байна.

Зураг 2. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн илрүүлэлтийн хувиар, /2015-2017 он/




Зураг 3. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 2015-2017 оны дундаж тоо, аймаг, дүүргээр.




Дээрх үзүүлэлтээс харахад нийслэлд болон хүн ам төвлөрсөн, нягтаршил ихтэй орон нутагт илүүтэй үйлдэгджээ. Орон нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн дундаж тоо 485, дунджаас дээгүүр 10 аймаг, доогуур үзүүлэлттэй 11 аймаг байна. Хамгийн өндөр үзүүлэлттэй нь Сэлэнгэ аймаг 750 хэрэг, хамгийн бага үзүүлэлттэй нь Говь-Алтай аймаг 218 байна. Харин нийслэлийн хувьд тухайн гэмт хэргийн дундаж нь 842 бөгөөд хамгийн өндөр үзүүлэлттэй Баянгол дүүргийн Цагдаагийн I дүгээр хэлтэс 1533, хамгийн бага үзүүлэлттэй Багахангай дүүргийн Цагдаагийн хэлтэс 27, бусад буюу хилийн чанадад 21 гэмт хэрэг гарсан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11 дүгээр бүлэг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 11.2, 11.3 дах зүйл ангиар 2017 оны 07 сараас 2017 оны 12 сарыг дуустал энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.


Зураг 3. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо, эрүүгийн зүйл ангиар, 2017 оноор.



Зураг 4. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэгт шалгагдсан этгээдийн гэм буруугийн хэлбэр



Зураг 5. Сogтуугаар үйлдэгдсэн Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг ЭХ-ийн зүйлээр




Зураг 6. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн газрыг 2017 оны байдлаар харуулбал:




Зураг 6-д Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2017 онд гэр орон сууцанд 3467 буюу 39.3 хувь, гудамж талбайд 2378 буюу 27.0 хувь, олон нийтийн газар 1509 буюу 17.1 хувь, бусад газар 877 буюу 9.9 хувь, нийтийн тээвэрт 372 буюу 4.2 хувь, авто зам дээр 15 буюу 0.2 хувь үйлдэгдсэн байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад олон нийтийн газар 21.1 хувь, төрийн байгууллагад 16.7 хувь, аж ахуйн нэгжид 14.8 хувь, гудамж талбайд 10 хувиар гэмт хэргийн гаралт тус тус өссөн байна.

Зураг 7, 8, 9-д хэрэг үйлдэгдсэн газрыг гудамж талбай, гэр орон сууц, олон нийтийн газраар нь задлан харуулав.

Зураг 7. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг “Гудамж талбай”-д үйлдэгдсэнийг тодруулан харуулбал:





Зураг 8. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг “Гэр орон сууц”-анд үйлдэгдсэнийг тодруулан харуулбал:



Зураг 9. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг “Олон нийтийн газар” үйлдэгдсэнийг тодруулан харуулбал:




Зураг 10. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 2015-2017 онд үйлдэгдсэн гэмт хэргийг гарсан гараг, цагаар харуулбал:



Зураг 10-д: 2015-2017 онд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хамгийн өндөр хувь нь 14.5-15.3 буюу 3647-3849 ажлын өдрүүдэд, цагаар авч үзвэл 5352 буюу 22 хувь нь 19-22 цагт, 9591 буюу 38 хувь нь 22-06 цагт үйлдэгдсэн байна.

Зураг 11. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн криминологи зураглал:



Зураг 11-д: Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн сүүлийн гурван жилийн өсөлтийн дундажаас харахад жилд дундажаар 2,8 хувийн өсөлттэй байх бөгөөд **2020** онд 9561 гэмт хэрэг бүртгэгдэх төлөвтэй байна.

Хоёр. Гэмт хэргийн хохирогч


Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 2015-2017 онд нийт 26067 хүн хохирсон бөгөөд 10159 эмэгтэй, 1126 хүүхэд байна. Хохирсон хүмүүсийг оноор нь харьцуулан харуулбал:

Хүснэгт 1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн тоо, хүйсээр:

Он	Хохирсон хүний тоо		
	Бүгд	Эмэгтэй	Хүүхэд
2015	8423	3379	373
2016	8664	3350	323
2017	8980	3430	430
Дүн	26067	10159	1126


Энэ гэмт хэргийн улмаас 2015-2017 онд нийт 40 хүн нас барж, 23638 хүн гэмтсэн бөгөөд үүнээс 2017 онд 22 хүн нас барж, 8024 хүн гэмтжээ.

Зураг 11. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчийн тоо, гэмт хэргийн зүйлчлэлээр:




Дээрх гэмт хэргийн улмаас 2017 онд нийт 8980 иргэн хохирсон нь өмнөх онтой харьцуулахад 316 буюу 3.6 хувиар өссөн бөгөөд 7580 буюу 84.4 хувь нь 99 -р зүйлийн гэмт хэргийн хохирогч байна.

Зураг 12. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо, зүйлчлэл, насны бүлгээр, 2017 оны байдлаар харуулбал:



Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн 35.1 хувь нь 18-29 насныхан, 32.3 хувь 30-39 насныхан, 18 хувь 40-49 насныхан байна.


Зураг 13. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирогчдын боловсролын байдал, хувиар:



Зураг 14-д улсын хэмжээнд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас 2015-2017 онд нийт 19921.3 сая төгрөгийн хохирол учирснаас 3137.8 сая төгрөгийн хохирлыг битүүмжилж, 15836.8 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн.


Үүнээс 2017 онд 7225.4 сая төгрөгийн хохирол учирсанаас 5150.0 сая төгрөг буюу 71,3 хувийг нөхөн төлүүлж, 1384.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна.

Зураг 14. Хүний эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын мөнгөн дүн, сая төгрөг, 2017 он:



Гурав. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт Холбогдогч


Зураг 15. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн тоо, 2015-2017 он:




Дээрх гэмт хэрэгт 2017 онд 7267 хүн, үүнээс 937 буюу 12.9 хувь нь эмэгтэй, 211 буюу 2.9 хувь нь хүүхэд байсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 1532 буюу 20.3 хувиар буурчээ. Насны бүлгээр авч үзвэл 2859 буюу 39.3 хувь 18-29 насны, 2370 буюу 32.6 хувь 30-39 насны, 1287 буюу 17 хувь нь 40-49 насны, 466 буюу 6 хувь нь 50-59 насны, 211 буюу 2.9 хувь нь насанд хүрээгүй хүн дээрх гэмт хэргийг үйлдсэн байна.

Зураг 16, 17, 18 -д хэрэгт холбогдсон сэжигтнийг насны бүлэг, гэмт хэргийн зүйлчлэл, нийгмийн байдлаар нь харуулав.


Зураг 16. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн сэжигтний тоо, насны бүлгээр нь:



Зураг 17. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн сэжигтний тоо, гэмт хэргийн зүйлчлэлээр, 2015-2017 он:




Зураг 18. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн сэжигтний тоо, нийгмийн байдлаар, 2015-2017 он:



Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний улмаас 974 хүн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан бөгөөд үйлдэгчийн талаар Зураг 18 -д тодруулан харууллаа.

Зураг 19. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн тоо, хамаатан садангийн байдал:




Дөрөв. Шүүх эмнэлгийн шинжилгээ

Шүүх шинжилгээний төвд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 2015 онд 31477, 2016 онд 30168, 2017 онд 27934 хүнд хийгдсэн. Үүнээс 2017 онд шинжилгээ хийгдсэн хүмүүсийн 14614 нь хөнгөн, 2263 нь хүндэвтэр, 1366 нь хүнд зэрэг гэж тогтоогдсон бөгөөд 6929 хүний гэмтлийн зэрэг тогтоогдоогүй байна.¹

Тав. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн талаар

Улсын хэмжээнд Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 2017 онд 4413 гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн нь нийт хэргийн 33.1 хувийг эзэлж байна.²

Зураг 20. Шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэргийн тоо, хуучин хуулийн зүйл ангиар:




Шүүхээс 2822 хүнд холбогдох 2609 хэргийг хянан шийдвэрлэж, 119 хүн буюу 4.2 хувьд нь хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 0.7 хувийг эрүүгийн хариуцлагаас

¹ Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтсийн тайлан

² Шүүхийн судалгаа мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээлэл

чөлөөлсөн бол 22.4 хувь нь урьд ял шийтгүүлж байсан хүн дахин дээрх гэмт хэргийг үйлдсэний улмаас дахин шүүхээр ял шийтгэгдсэн байна.


Зураг 20. Оногдуулсан ялын төрөл, хувиар:



Зургаа. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас ял эдлэж буй хүний тоо

Монгол улсын Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 96-100 дугаар зүйл анги /хуучин хууль/, 11.1-11.7 дугаар зүйл ангиар /шинэ хуулиар/ гэм буруутай нь шүүхээр тогтоогдон ял шийтгүүлсэн 286 ялтан одоо ял эдлэж байна.³

Зураг 21. Ял шийтгэгдсэн хүний тоо, 2015-2017 он:



ДҮГНЭЛТ

1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2015-2017 онд 25124 бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 29 хувийг эзэлж байна.
2. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 84 хувь нь Монгол улсын Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйл анги /Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах/-иар зүйлчлэгдэн шалгагджээ.
3. Энэ төрлийн гэмт хэргийн 60.2 хувь нь нийслэл хотод үйлдэгдсэн бөгөөд 39.3 хувь нь гэр орон сууцанд, 47.9 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй хүн үйлдсэн байна.
4. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн 39.3 хувь нь 18-29 насны, 32.6 хувь нь 30-39 насныхан байна. Залуучууд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нь эр, эмийн хардалт, өр авлага, хохирогчийн

³ Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын тоо бүртгэл

буруутай үйл ажиллагаа буюу хувийн тааламжгүй харьцаа, хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгаагаас бусдын эрх чөлөөнд нь халдаж улмаар бие махбодид гэмтэл учруулж байна.

5. Энэ төрлийн гэмт хэргийн 60 хувь нь 19-06 цагт, 39.6 хувь нь архидан согтуурсны улмаас үйлдэгдсэн статистик үзүүлэлтээс харахад Нийслэлийн Засаг даргын захирамжаар⁴ согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 04.00 цаг хүртэл ажиллуулж байгаа нь шөнийн цагаар гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлж байна.
6. Олон нийтийн газруудад байрлуулсан хяналтын камер шаардлага хангахгүй, ихэнх нь эвдэрсэн, хүний нүүр царай болон авто машины дугаар зэргийг тодруулан харах боломжгүй байгаа нь хяналт тавих, хэрэг зөрчлийг илрүүлэх, улмаар цагдаагийн байгууллагад итгэх иргэдийн итгэлд сөргөөр нөлөөлж байна.
7. Цагдаагийн байгууллагад ирж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага мэдээллийн багагүй хувийг гэр хороололд баригдсан түрээсийн “Нийтийн байр”-нд оршин суудаг иргэдээс ирүүлдэг бөгөөд нийслэлд 640⁵ орчим нийтийн байр байдаг байна. Энд голдуу оршин суух тодорхой хаяггүй хүмүүс амьдардаг, архидалт ихтэй, хяналтгүй, жижүүр манаач болон камергүй, орчны гэрэлтүүлэг муутай, байр түрээслэгчид оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцлийг хангах чиглэлээр хариуцлагагүй ханддаг зэрэг шалтгааны улмаас гэмт хэрэг, зөрчил ихээр гардаг байна.
8. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 2002 оны Эрүүгийн хуулиар торгох, албадан ажил хийлгэх, баривчлах, хорих ял оногдуулж байсан нь харьцангуй ялын бодлого зөөлөн байсны зэрэгцээ хохирогч, яллагдагчтай эвлэрсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болдог байсан бол одоо шүүхээр шийдвэрлэдэг болсон нь ялтай хүний тоог эрс нэмэгдүүлэх, цаашлаад хувь хүний нийгмийн асуудалд учрах хор уршиг өндөр байх тул энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

САНАЛ

Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас зохион байгуулах ажил, арга хэмжээний талаар доорх саналыг танилцуулж байна. Үүнд:

1. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өссөн /Төв, Хөвсгөл, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгийн Цагдаагийн газар, Баянгол дүүргийн Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Баянзүрх дүүргийн Цагдаагийн 1,2 дугаар хэлтэс,

⁴ Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/609 дугаар захирамж /2015.07.09/

⁵ Нийслэлийн Цагдаагийн газрын судалгаа /2017 он/

Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 1 хэлтсүүд энэ төрлийн гэмт хэрэг гарч буй шалтгаан нөхцлийг нарийвчлан судлаж, бодитой тогтоон, түүнийг арилгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх ажлыг нутаг дэвсгэрийн төрийн захиргаа, мэргэжлийн хяналт, хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллагын идэвхи оролцоонд түшиглэн зохион байгуулж, үр дүнг тооцох;

2. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд нь энэ төрлийн гэмт хэрэг ихээр гарч байгаа олон нийтийн газар, бар ресторан, зочид буудлууд зэрэг тухайн гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газруудад хяналтын камерыг жигд ажлуулж, хянах, гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг жигдрүүлэн нэмэгдүүлэх, эргүүлийн чиглэлийг Криминологи судалгааны багийн зөвлөмжид заагдсаны дагуу томилж, хууль зөрчигчдөд оногдуулж байгаа хариуцлагын үр нөлөөг судлан хэлэлцэж, зөрчил дутагдал гаргасан аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцох;
3. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд дүүрэг, хорооны мэргэжилтэн, нийгмийн ажилтан, хэсгийн дарга, СӨХ-тэй хамтран “Хөршийн холбоо”-г идэвхижүүлэх, архи дан согтуурч, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг хүмүүсийн бүртгэл судалгааг шинэчилж, тэднийг хяналтад авах, хуулийн хариуцлага тооцох, холбогдох хууль тогтоомжийг судлуулж ойлгуулах ажлыг хэвшүүлэх;
4. Урьдчилан сэргийлэх хэлтэс судалгааны байгууллагатай хамтран холбогдох газрууд, ард, иргэдээс санал авч, архи согтууруулах ундааны нийгмийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, улмаар архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүдийн тоонд хязгаарлалт тогтоолгох, цагийн хязгаарыг шинэчлэх, цэгийн тоог багасгах талаар санал боловсруулж хүргүүлэн, шийдвэрийг хэрэгжүүлэх;
5. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хор уршиг, оногдуулах хуулийн хариуцлагын талаар санамж, сэрэмжлүүлгийг ард иргэд, залуучуудад хэвлэл мэдээлэлээр болон зар сурталчилгааны хэрэгслүүдээр тогтмол явуулах;
6. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсүүд уул уурхай, барилгын ажлын улирал эхлэж байгаатай холбогдуулан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, журмыг хэрэгжүүлэх, иргэдийн эрүүл мэндэд хохирол учрахаас сэргийлэх чиглэлээр харьяа нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд тусгайлан анхааруулсан мэдэгдэл хүргүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулах саналтай байна.

МЭДЭЭЛЭЛ НЭГТГЭН БОЛОВСРУУЛАХ ГАЗАР